



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2019-
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: АГГ-2021/01-ШТА-ГА

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ
НӨХЦЛӨӨР ОЛГОСОН 729.3 САЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ТӨЛӨГДӨХ
ХУГАЦАА ХЭТЭРСЭН БАЙНА.**

Баян-Өлгий аймаг 2021 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас:70422954 цахим хуудас:
Khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 цахим хуудас:
jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524
Цахим хуудас: manargulx@audi.gov.mn
Аудитор Р.Баярмаа
Утас:99265539
Цахим хуудас: bayarmaar@audit.gov.mn
Аудитор Х.Еркебулан Утас:99999844 Цахим хуудас:
erkebulan.kh@audit.gov.mn
Энэхүү аудиттай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах ягаар авна уу.Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн тайлбар.....	
Хүснэгт, графикийн товъёог.....	
Хавсралтын товъёог.....	
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
БҮЛЭГ 1. ХЭДС-ГААС ЭРГЭН ТӨЛӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ	
АВСАН 441 АЖ АХУЙН, НЭГЖ, ИРГЭН 729,3 САЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ЭРГЭН	
ТӨЛӨХ ХУГАЦААГ ХЭТРҮҮЛСЭН БАЙНА	
А.1. ХЭДСан нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдсөн байна.....	
А.1.1. Батлагдсан төсөл, хөтөлбөр, салбарын бодлоготой уялдсан байна. .10	
А.1.3. Батлагдсан төсөл, хөтөлбөр салбарын байгууллагын саналд	
үндэслэгдсэн байна.12	
А.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрөөс нийт	
14,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.....15	
А.2.4. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн орлогоос 24,1	
сая төгрөг бүрдүүлсэн байна.....16	
БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ	
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.	
Б.1. Дэмжих сангийн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг тооцож, үнэлэх арга	
хэмжээ дутагдалтай байна.....17	
Б.1.1. ХЭДСангаас хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөрүүд зохих үр дүнгээ	
өгсөн байна.....17	
Б.1.2. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх иргэн аж ахуйн нэгжид гэрээ байгуулсан	
боловч гэрээний үр дүнг тооцож, үнэлэх арга хэмжээ дутагдалтай байна..23	
Б.2. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....23	
Б.2.1. ХЭДСангийн батлагдсан төсвийг хуваарийн дагуу бүрэн	
санхүүжүүлээгүй байна.23	
Б.2.2. Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион	
байгуулсан байна.24	
Б.2.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....25	
БҮЛЭГ 3. В. САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨ	
БАГАТАЙ БАЙНА.....	
В.2. ХЭДСангийн эргэн төлөлтөд тавих хяналтын үр нөлөө бага байна.....37	
В.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтөд тавих хяналтын	
үр нөлөө бага байна.....37	
В.2.2. 2019, 2020 онуудад хэрэгжсэн хөтөлбөрийн явцын хяналтыг	
байгууллагын дотоод хяналтын зүгээс бүрэн хэрэгжүүлээгүй, дүн шинжилгээ,	

үнэлгээ хийсэн талаар тайлагнаагүй байна.	38
Холбогдох байгууллагын санал:	
ДҮГНЭЛТ: 42	
А.1. ХЭДСан нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдсөн байна.	
А.1.1. Батлагдсан төсөл, хөтөлбөр, салбарын бодлоготой уялдсан байна.	42
А.2.2. 441 аж ахуйн, нэгж, иргэн 729,3 сая төгрөгийн төслийн зээлийн эргэн төлөх хугацааг хэтрүүлсэн байна.	Error! Bookmark not defined.
А.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрөөс нийт 14,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.	42
А.2.4. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн орлогоос 24060,0 мянган төгрөг бүрдүүлсэн байна.	42
Б.1.1. Аудитын явцад газар дээр нь хэрэгжилтийг шалгасан төсөл хөтөлбөрүүд зохих үр дүнгээ өгсөн байна.	Error! Bookmark not defined.
Б.1.2. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх иргэн аж ахуйн нэгжид гэрээ байгуулсан боловч гэрээний үр дүнг тооцож, үнэлэх арга хэмжээ дутагдалтай байна.	42
Б.2.1. Сангийн хөрөнгийн батлагдсан төсвийг хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээгүй байна.	Error! Bookmark not defined.
Б.2.2. Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	42
Б.2.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	Error! Bookmark not defined.
БҮЛЭГ 3. В. САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА.	42
В.1.3. Сангийн хөрөнгийг зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт зохих түвшинд хэрэгжиж ирсэн байна.	42
ЗӨВЛӨМЖ: 43	
ХАВСРАЛТУУД:	

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Хүснэгт, графикийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2020 онд тодотгосон төсөв	11
Хүснэгт 2	Төсвийн төсөл, тодотголоор хамгийн сүүлд батлагдсан төлөвлөгөөг харьцуулсан судалгаа	11
Хүснэгт 3	Аймгийн ХЭДСангийн 2019, 2020 оны төсвийн эх үүсвэрийн бүрдүүлэлт	11-12
Хүснэгт 4	ХЭДС-аас эргэн төлөх нөхцөлөөр олгосон зээлийн төлөлт	13-14
Хүснэгт 5	2019, 2020 онд ХЭДС-д хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөр төлсөн байгууллагууд	15
Хүснэгт 6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2019-2020 онуудад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн хамрагдалтын судалгаа	17
Хүснэгт 7	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ	18
Хүснэгт 8	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгаа	21
Хүснэгт 9	Ажил зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгаа	22
Хүснэгт 10	ХЭДС-гаас 2019,2020 онуудад эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэг	25
Хүснэгт 11	2019, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл	25
Хүснэгт 12	2019 онд хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгө	26
Хүснэгт 13	2019, 2020 онуудад ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгө	27
Хүснэгт 14	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн 2019, 2020 онуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл	30
Хүснэгт 15	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	30
Хүснэгт 16	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	31
Хүснэгт 17	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	32
Хүснэгт 18	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн төлөвлөгөө, гүйцэтгэл	33
Хүснэгт 19	2019, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл	34
Хүснэгт		

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	2019, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл	45
Хавсралт 2	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн судалгаа	46
Хавсралт 3	Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн судалгаа	46
Хавсралт 4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн 2019, 2020 онуудын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа	46-47
Хавсралт 5	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа	47
Хавсралт 6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа	47-48
Хавсралт 7	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа	48
Хавсралт 8	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа	48
Хавсралт 9	2019, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа	48-49

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А128 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны үйл ажиллагааны, үр дүн"-д гүйцэтгэлийн аудит хийлээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • ХЭДСангийн орлогын бүрдүүлэлт үр ашигтай байгаа эсэх • ХЭДСангийн хөрөнгийн зарцуулалт үр дүнтэй, үр ашигтай байгаа эсэх • Дотоодын хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулж, сангийн үйл ажиллагааны ажлын тайлан, санхүүгийн тайлан, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл болон хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотой санхүүгийн болон бусад баримт материалыг хамруулан шалгалаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ /INTOSAI/-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит. Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", Гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан баримт материалыг шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Женисбек хэрэгжүүлж, ахлах аудитор Х.Манаргүл, аудитор Х.Еркебулан, Р.Баярмаа нар хамтран гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Аудитын хамрах хүрээ өргөн, аудит хийх хугацаа бага, аудитын хугацаанд багийн зарим гишүүд өвдөж эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн, ҮАГ-ын чиглэлийн дагуу 2019-2021 оны СТА, ГА, НА-ын статистик мэдээг программд оруулсан, цар тахал Ковид 19 өвчин гарсантай холбоотой багийн нэг гишүүн болон шалгагдагч байгууллагын холбогдох мэргэжилтнүүд гэрийн тусгаарлалтад орсон зэрэг нь аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажил удааширахад нөлөөлсөн.

Мөн тус аймагт цар тахал Ковид 19 өвчин гарсантай холбоотой аудитын явцад зарим төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж чадаагүй санхүүгийн холбогдох материалуудад тулгуурлан дүгнэлт гаргасан болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөр”, 2020 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, төсөв батлах тухай” хууль, эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/60 дугаар тушаалаар баталсан 2019 онд хэрэгжүүлэх 9 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ХХҮЕГ-ын даргын 2020 оны А/186 тоот тушаалаар баталсан 6 төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.Үүнд:

№	Хөтөлбөрийн нэр	2019 он	2020 он
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1	1
2	Ажилд зуучлах үйлчилгээ	1	1
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	1	1
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	1	1
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	1	
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	1	
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	1	1
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	1	1
9	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	1	
ХЭДС-ийн төсөл, хөтөлбөр болон арга хэмжээ дүн		9	6

ХЭДС-ийн хөрөнгийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээ, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр, Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 12 сум, 1 тосгоны иргэд хамрагдсан байна.

БҮЛЭГ 1. ХЭДС-ГААС ЭРГЭН ТӨЛӨХ НӨХЦӨЛТЭЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ АВСАН 441 АЖ АХУЙН, НЭГЖ, ИРГЭН 729,3 САЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨХ ХУГАЦААГ ХЭТРҮҮЛСЭН БАЙНА

А.1. ХЭДСан нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдсөн байна

А.1.1. Батлагдсан төсөл, хөтөлбөр, салбарын бодлоготой уялдсан байна

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тугагдсан “Гэр бүлийг тэтгэх, иргэн бүр эрүүл боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч, ажилгүйдэл, ядууралыг бууруулан, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулах” гэсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төсөл хөтөлбөрүүд батлагдаж хэрэгжсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай аймгийн ХХҮГ-ын даргын байгуулсан гэрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг тусган харьяа байгууллагын саналыг үндэслэн санхүүжилтийг баталсан байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт малжуулах арга хэмжээ, санхүүгийн дэмжлэг олгох, мэргэжлийн сургалт зохион байгуулах, хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнүүд, нийтийг хамарсан ажил гэх мэт нийтлэг хэрэгждэг төсөл, арга хэмжээнүүдийг тусгасан байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлагдсан төсөл, хөтөлбөрүүд нь салбарын бодлоготой уялдсан байна.

А.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас 2020 онд цар тахалтай холбоотой төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг дутуу олгосон байна

ХЭДС-ийн орлогын эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөр, жижиг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс бүрддэг байна.

Сангийн төсвийн төслийг боловсруулахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо, сангийн өмнөх оны гүйцэтгэл зэргийг үндэслэн хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж ХХҮЕГ-т 2019 онд 1970,6 сая төгрөгийн төсвийн санал хүргүүлснээс 581,9 сая төгрөгөөр бууруулан 1388,6 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Харин 2020 онд холбогдох дээд шатны байгууллагад 1615,4 сая төгрөгийг төсвийн төслийн санал хүргүүлснээс Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/18 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 341,2 сая төгрөгөөр өсгөж 1956,6 сая төгрөгөөр баталсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны төсвийг жилийн турш 4 удаа тодотгож, 2020 оны 12 дугаар сард ХХҮЕГ-ын даргын А/186 дугаар тушаалаар 753,1 сая төгрөг болгон өөрчилж баталсан байна. Энэ нь оны эхэнд баталсан төсвөөс 61.5 хувиар буюу 1203,5 сая төгрөгөөр буурсан байна.

2020 онд тодотгосон төсвийг хүснэгтээр харуулахад:

Хүснэгт №1

/Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ХХҮЕГ-ын даргын 2020.02.06-ны өдрийн А/18 тоот тушаал	ХХҮЕГ-ын даргын 2020.06.12-ны өдрийн А/114 тоот тушаал	ХХҮЕГ-ын даргын 2020.07.03-ны өдрийн А/126 тоот тушаал	ХХҮЕГ-ын даргын 2020.10.12-ны өдрийн А/166 тоот тушаал	ХХҮЕГ-ын даргын 2020.12.03-ны өдрийн А/186 тоот тушаал
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн санхүүжилт	1,172,718.0	1,206,450.1	1,296,450.1	702,671.9	750,644.2
2	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж	781,441.0				
3	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	2,500.0	2,500.0	2,500.0	2,500.0	2,500.0
	Дүн	1,956,659.0	1,208,950.1	1,298,950.1	705,171.9	753,144.2

/Эх сурвалж: ХХҮЕГ-ын даргын тушаалын хавсралтуудаас/

2020 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр 753,1 сая төгрөгийн төсөв баталснаас 750,6 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас санхүүжүүлж, 2,5 сая төгрөгийг ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ

Төсвийн төсөл, тодотголоор батлагдсан төлөвлөгөөг харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №2

/Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2019 он			2020 он		
		Хүргүүлсэн төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү	Хүргүүлсэн төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү
1	Тайлант онд санхүүжих	1,970,560.0	1,388,581.0	581,979.0	1,615,400.0	753,144.2	862,255.8

/Эх сурвалж: ХЭДС-гийн 2019, 2020 оны 4-р улирлын санхүүгийн тайлан/

2020 оны батлагдсан төсвийг өмнөх оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 45.8 хувиар буюу 635,4 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь цар тахлын нөхцөл байдалтай холбоотой зарим төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Аймгийн ХЭДСангийн 2019, 2020 оны төсвийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг хүснэгтээр харуулав:

Хүснэгт №3

/Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2019 он		2020 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн санхүүжилт	1,388,581.0	1,354,000.0	750,644.2	583,032.1
2	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж			-	24,060.0
3	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	-	7,257.6	2,500.0	7,646.9
4	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	289,114.1	-	260,355.8

5	Өмнөх оны үлдэгдэл		1,012.5	-	-
	Орлогын нийт дүн	1,388,581.0	1,651,384.2	753,144.2	875,094.8

/Эх сурвалж: ХЭДС-гийн 2019, 2020 оны 4-р улирлын санхүүгийн тайлан, ХХҮГ-ын холбогдох материал/

Санд төвлөрсөн нийт орлогын 66.6 хувийг ХЭДСангаас авсан санхүүжилт, 2.7 хувийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”, 29.8 хувийг санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, 0.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого эзэлж байна.

2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас 750,6 сая төгрөгийн санхүүжилт авахаас гүйцэтгэлээр 583,0 сая төгрөгийн санхүүжилт авч 22.3 хувь буюу 167,6 сая төгрөгийг дутуу авсан байна. Энэ нь цар тахалтай холбоотой төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг бүрэн олгоогүйтэй холбоотой байна.

ХБИ ажиллуулаагүйн төлбөрөөс 7,6 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 5,0 сая төгрөгийг илүү төвлөрүүлж, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 284,4 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлого оруулжээ.

Туслах үйл ажиллагааны орлогын 91,5 хувь буюу 260,3 сая төгрөг нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 4-р зүйлийн 4.8, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 6-р зүйлийн 6.1, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 3-р зүйлийн 3.3-т, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр-ийн 4-р зүйлийн 4.3.1, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 6-р зүйлийн 6.3-т тус тус заасан болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 02 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”-ийн 6-р зүйлийн 6.10-т заасны дагуу төлсөн эргэн төлөлтөөс бүрдсэн байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-өөр 24,1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

А.1.3. Батлагдсан төсөл, хөтөлбөр салбарын байгууллагын саналд үндэслэгдсэн байна

Төсөл, хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцэж баталдаг бөгөөд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга болон мэргэжилтнүүдээс санал авч өнгөрсөн хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх явцад тулгарсан бэрхшээлийн талаар болон хэрэгцээ, шаардлага багатай арга хэмжээнүүдийг хэлэлцэж дараагийн төсөл, хөтөлбөр батлахад анхаарч хэрэгжээгүй, үр дүн багатай арга хэмжээнд дүгнэлт хийж үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт хийдэг байна.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар сум болон бусад холбогдох газруудаас авсан саналыг ХХҮЕГ-т нэгтгэж хүргүүлсэн байна.

А.2. ХЭДС-гаас эргэн төлөх нөхцөлтэй зээл авсан 441 аж ахуйн, нэгж, иргэн 729,3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөх хугацааг хэтрүүлсэн байна

2.1.1. Төсөл, хөтөлбөрийн жагсаалтад нэр, хэрэгжих хугацаа тодорхойгүй төсөл, арга хэмжээг батлагдаагүй байна

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөр”-үүдийг, 2019 оны 02 дугаар тогтоолоор “Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”-ийг, 2020 оны 01 дүгээр “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах, төсөв батлах тухай” тогтоолоор 2020 оны төсвийг тус тус баталсан байна. Үүнд:

1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
3. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
4. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
6. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр
7. Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

2019, 2020 онуудад хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалтад нэр, хэрэгжих хугацаа тодорхойгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгдөж батлагдаагүй байна.

А.2.2. 441 аж ахуйн, нэгж, иргэн 729,3 сая төгрөгийн төслийн зээлийн эргэн төлөх хугацааг хэтрүүлсэн байна

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжид эргэн төлөх нөхцөлөөр хүүгүй болон хөнгөлөлттэй олгосон нийт зээлийн авлагын үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 557,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрөөс эргэн төлөх нөхцөлтэй олгосон 47 иргэнээс 59,3 сая, АБДэмжих хөтөлбөрөөс эргэн төлөх нөхцөлтэй олгосон 237 иргэнээс 551,7 сая, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс эргэн төлөх нөхцөлтэй олгосон 35 иргэнээс 190,2 сая, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс эргэн төлөх нөхцөлтэй олгосон 177 иргэнээс 436,4 сая, ХБИ ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс эргэн төлөх нөхцөлтэй олгосон 85 иргэнээс 132,8 сая, Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслөөс эргэн төлөх нөхцөлтэй олгосон 9 иргэн, аж ахуйн нэгжээс 187,2 сая төгрөг байна.

Аудитын явцад зээлийн эргэн төлөлтийг иргэн, аж ахуй нэгж бүрээр тулган 2021 оны 5 дугаар сарын 30-ны хүртэлх зээлийн төлөлтийг оруулан шалгаж үзэхэд 441 иргэн аж ахуйн нэгжийн нийтдээ 729,3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагатай байгааг нь нийт авлагын 52.4 хувийг эзэлж байна.

ХЭДС-аас эргэн төлөх нөхцөлөөр олгосон зээлийн төлөлтийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №4				/Мянган төгрөгөөр/		
№	Эргэн төлөх нөхцөлөөр зээл олгосон төсөл хөтөлбөр нэр	Төсөл хэрэгжүүлэгч ийн тоо	Нийт төлөх ёстой үлдэгдэл /2020.12.31/	Хугацаа болоогүй зээлийн дүн	Хугацаа хэтэрсэн зээлдэгчийн тоо	Хугацаа хэтэрсэн зээл мөнгөн дүн
1	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	47	59,306.0	18,000.0	35	31,490.0
2	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	237	551,732.1	290,722.1	194	222,705.7
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	35	190,237.8	56,250.0	31	124,819.6

4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	177	436,444.6	121,524.0	127	219,889.2
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	85	132,855.1	58,765.6	46	61,045.9
6	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	9	187,235.0	117,900.0	8	69,395.0
ДҮН		590	1,557,810.6	663,161.7	441	729,345.5

/Эх сурвалж: 2019,2020 оны 4-р улирлын санхүүгийн тайлан, аймгийн ХХҮГ-ын холбогдох материалаас/

Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.1-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийг хөтлөх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гүйцэтгэнэ”,

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн” 3.3-д “Санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авч өгснөөс хойш 36 сарын дотор хуваарийн дагуу 100 хувь эргүүлэн төлнө”, Өрхийн малжуулах гэрээний 1 дүгээр зүйлийн 1.2-д “Гэрээг 36 сарын дотор В тал хавсралтад тусгасан эргэн төлөлт хийх хуваарийн дагуу төлж барагдуулна”,

“Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”-ийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хэрэгжүүлэх хамтран ажиллах гэрээний 1.5-д ” дансанд шилжиж орсноос хойш 36 сарын дотор хавсралтад тусгасан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу төлж барагдуулахаар харилцан тохиролцов”,

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 6.3-д “Санхүүгийн дэмжлэг нь 24 сарын дотор 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг иргэний саналыг үндэслэн тогтоож, холбогдох гэрээнд тусгана”, “Аж ахуй өрхийн үйлдвэрлэл эрхлэгч ахмад мэргэжилтэнд эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээний 1.3-д ” дансанд шилжиж орсноос хойш 24 сарын дотор хавсралтад тусгасан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу төлж барагдуулахаар харилцан тохиролцов”,

Ажлын байрыг дэмжих хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн гэрээний 1.8-д “Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг үүрэг гүйцэтгэгч тал үүрэг гүйцэтгүүлэгч талд эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулна гэж гуравдагч этгээд үүрэг гүйцэтгүүлэгчтэй үүрэг гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс батлан даалтын гэрээг заавал байгуулна”,

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”- ийн “Гарааны бизнес эрхлэх залуучуудын бүлэгт эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээний 1.3-д ” дансанд шилжиж орсноос хойш 36 сарын дотор хавсралтад тусгасан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу төлж барагдуулахаар харилцан тохиролцов” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Аудитын дүнгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зургаан төсөл хөтөлбөрөөс эргэн төлөх нөхцөлтэйгээр олгосон зээлийг хуваарийн дагуу гэрээнд заасан хугацаанд төлөөгүй 441 иргэн, аж ахуйн нэгжийн хугацаа хэтэрсэн 729,3 сая төгрөгийн зээлийг санд эргэн төлүүлэх арга хэмжээ авах талаар зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

А.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрөөс нийт 14,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг баталсан байна.

№	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо (бүсээр)	Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулах орон тоог аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагчдын 25 хүн тутамд 1 гэж тооцох
1.	Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймаг	Тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн хэмжээгээр
2.	Бусад аймаг	Тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар

Аймгийн статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас үзэхэд 2019 онд үйл ажиллагаа явуулж байгаа 20-49 ажилтантай 109, 50-иас дээш ажилтантай 47, 2020 онд үйл ажиллагаа явуулж байгаа 20-49 ажилтантай 108, 50-иас дээш ажилтантай 45, дунджаар 154 аж ахуйн нэгж байна.

2019, 2020 онд ХЭДС-д хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөр төлсөн байгууллагуудыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №5

/Мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	2019 он	2020 он	Нийт
1	Хаан банк	3,840.0	4,992.0	8,832.0
2	Төрийн банк	936.0		936.0
3	ЦШСГазар	921.6	378.0	1,299.6
4	Ногооннуур ахлах сургууль	600.0	800.0	1,400.0
5	Цэнгэл ахлах сургууль	960.0		960.0
6	Алтай сумын хүн эмнэлэг		500.0	500.0
7	Мори Сувд ХХК		378.0	378.0
8	"Ник" ХХК		598.9	598.9
Дүн		7,257.6	7,646.9	14,904.5

/Эх сурвалж: аймгийн ХХҮГ-ын санхүүгийн материал/

Аймгийн ХХҮГазар Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн асуудал хариуцсан улсын байцаагчтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрт, 2019 онд 5, 2020 онд 6 аж ахуйн нэгж, байгууллагаас нийтдээ 14,9 сая төгрөгийн төлбөрийг төвлөрүүлсэн байна.

2019 онд 58, 2020 онд 38 аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн харилцааны чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллажээ.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтны тоо, ажиллаж буй ХБИ, одой хүний судалгааг гаргаж, Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэхгүй байгаа байгууллагуудад шаардлага тавьж ажилладаг боловч төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

ХЭДС-д хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрийн орлогын гүйцэтгэлийг сүүлийн 5 жилийн байдлаар графикаар үзүүлэв.

График 1

/мянган төгрөг/



Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрөөс 2016 онд 0,3 сая, 2017 онд 6,2 сая, 2018 онд 0,6 сая, 2019 онд 7,3 сая, 2020 онд 7,6 сая төгрөг оруулсан байна.

А.2.4. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн орлогоос 24,1 сая төгрөг бүрдүүлсэн байна

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-т 24,1 сая төгрөгийн санхүүжилт авч 5,9 сая төгрөгийг зарцуулж, 18,2 сая төгрөгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА**Б.1. Дэмжих сангийн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг тооцож, үнэлэх арга хэмжээ дутагдалтай байна****Б.1.1. ХЭДСангаас хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөрүүд зохих үр дүнгээ өгсөн байна**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөр”-үүдийг баталсан байна. Үүнээс тус аймагт 2019 онд 6 хөтөлбөр, 2 төсөл, 2020 онд 3 хөтөлбөр, 1 төсөл хэрэгжсэн байна. Хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хамрагдалт, зарцуулсан хөрөнгө, үр дүнг авч үзвэл:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2019-2020 онуудад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн хамрагдалтын судалгаа

Хүснэгт № 6

мянган төгрөгөөр

№	Хөтөлбөрийн нэр	2019 он					2020 он					Нийт дүн				
		Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Бий болсон ажлын байрны тоо	Байнгын ажлын байр	Түр ажлын байр	Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Бий болсон ажлын байрны тоо	Байнгын ажлын байр	Түр ажлын байр	Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Бий болсон ажлын байрны тоо	Байнгын ажлын байр	Түр ажлын байр
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	687	523220.0	592	151	441	571	375583.3	385	111	274	1279	898803.3	977	262	715
2	Хөгжлийн бэршээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	107	83949.2	27	27		65	89277.5	34	34		134	173226.7	61	61	0
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	336	177715.0	47	47							383	177715.0	47	47	0
4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	185	278807.2	114	114							299	278807.2	114	114	0
5	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	296	35401.0	125	89	36						421	35401.0	125	89	36
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	45	41200.0	45	22	23	15	30000.0	15	15		90	71200.0	60	37	23
7	Жижиг зээл	24	592000.0	36	36		63	361000.0	67			60	953000.0	103	36	0
8	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	6	100000.0	15								21	100000.0	15	0	0
Дүн		1686	1832292.4	1001	486	500	714	855860.8	501	160	274	2687	2688153.2	1502	646	774

Дээрх хүснэгтээс үзэхэд 2019 онд хэрэгжүүлсэн 8 төсөл, хөтөлбөрт 1686 иргэн, аж ахуйн нэгж төсөл ирүүлснээс 1001 иргэн, аж ахуйн нэгж шалгарч 486 байнгын, 500 түр ажлын байр, 2020 онд онд хэрэгжүүлсэн 4 төсөл, хөтөлбөрт 714 иргэн, аж ахуйн нэгж төсөл ирүүлснээс 501 иргэн, аж ахуйн нэгж шалгарч 160 байнгын, 274 түр ажлын байр тус тус бий болсон байна.

ХЭДС-ийн төсөл, хөтөлбөр болон арга хэмжээний хэрэгжилтийг төсөл, хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр задалж харуулахад:

I. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:

1.“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох хөтөлбөр” 2019 онд хэрэгжиж хөтөлбөрийн хүрээнд 5 байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ хийж, 7 төрлийн сургалт зохион байгуулж, 281 иргэнийг хамруулсан байна.

“Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох”
хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ

Хүснэгт № 7		мянган төгрөгөөр			
№	Сургалт явуулсан байгууллага	Сургалтын төрөл	Сургалтын чиглэл	Хамрагдсан хүний тоо	Нийт зардал
1	Мөнх алтан хүлэг ХХК	Мэргэжлийн болон давтан явуулын сургалт	Тогооч	43	3870.00
2	Мөнх алтан хүлэг ХХК	Мэргэжлийн болон давтан явуулын сургалт	Худалдагч, касс нярав	46	3215.40
3	МСҮТөв	Мэргэжлийн болон давтан явуулын сургалт	Мужаан	15	3600.00
4	МСҮТөв	Мэргэжлийн болон давтан явуулын сургалт	Үсчин	17	1815.60
5	"Күмис ине" ХХК	Үйлдвэр дээрх сургалт	нэхмэл оёдол	25	9000.00
6	"Алтайн Алтан орд" ХХК	Үйлдвэр дээрх сургалт	Цахилгаанчин, гагнуурчин	15	8100.00
7	МХНМХолбоо	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт		120	5400.00
	Дүн			281	35001.00

- Мэргэжлийн давтан явуулын сургалтаар аймгийн МСҮТөвтэй гэрээ хийж иргэнийг тогооч, худалдагч-касс няравын мэргэжлээр сургаж, сертификат олгосон.
- Үйлдвэрлэл дээрх сургалтаар “Күмис ине” ХХК-тай хамтран 25 иргэнийг оёдол нэхмэл, “Алтайн алтан орд” ХХК-тай хамтран 15 иргэнийг цахилгаанчин гагнуурчин мэргэжлээр сургасан.
- Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн үйлдвэр дээрх сургалтыг зохион байгуулсан “Күмис ине”, “Алтайн алтан орд” ХХК-иудын баримт материал Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн газарт шалгагдаж Прокурорын газраас 2021.04.01-ний өдрийн 36 тоот хэрэг бүртгэлийг хэрэгсэхгүй болгосон тогтоол гарсан байна. Санхүүгийн материалыг Цагдаагийн газраас хүлээлгэж өгөөгүй байгаа тул шалгах боломжгүй байв.
- Хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг МХНМХолбоотой хамтран зохион байгуулж, 120 иргэнийг хамруулсан байна.

Дээрх хөтөлбөрийн үр дүнд 161 иргэнд тогооч, худалдагч касс, нярав, нэхмэл оёдол, мужаан, цахилгаанчин гагнуурчин мэргэжил олгож, 120 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгосон байна. Сургалтанд хамрагдсан иргэдээс 89 нь байнгын ажлын байртай болсон байна.

2.“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн “Зөвлөх үйлчилгээ” арга хэмжээний хүрээнд 2019 онд 25 ахмад мэргэжилтэнтэй “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний гэрээ” хийж зөвлөх үйлчилгээг үзүүлсэн бол “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн

дэмжлэг” арга хэмжээний хүрээнд 2019 онд 20, 2020 онд 15 ахмадад 24 сарын хугацаатай санхүүгийн дэмжлэгийг гэрээ хийж олгосон байна.

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ”-д хамрагдсан 25 ахмад нь багш /математик, гадаад хэл, уран зохиол, түүх газар зүй, дуу хөгжим, бага ангийн/, эмч, барилгын инженер, эдийн засагч, нягтлан бодогч, агрономич, малын эмч мэргэжилтэй бүгд өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настнууд байна. Зөвлөх үйлчилгээг үзүүлсэн чиглэлийг авч үзвэл боловсрол 8 буюу 32 хувь, эрүүл мэнд, барилгын ХАБЭА тус бүр 3 буюу 12 хувь, газар тариалан, мал аж ахуй, хүүхэд хамгаалал тус бүр 2 буюу 8 хувь, ХАА-н үйлдвэрлэл, авто засварын хөдөлмөр хамгаалал, нягтлан бодох бүртгэл, соёл урлаг, төрийн захиргааны чиглэлээр тус бүр 1 буюу 4 хувийг эзэлж байна.

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг” арга хэмжээнд 2019 онд 20 ахмадын оёдол, гар урлал, үнээний ферм, мужаан, гутал засвар зэрэг чиглэлээр бичиж ирүүлсэн төсөл шалгарч 1,0-3,0 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон бол 2020 онд 15 ахмадын оёдол, эсгий үйлдвэрлэл, нарийн боов, үнээний ферм гагнуур зэрэг төсөл хөтөлбөрийг шалгаруулж тус бүр 2,0 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна.

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх” хөтөлбөрийн үр дүнд нийт 60 ахмад хамрагдаж 37 иргэн байнгын, 23 иргэн түр ажлын байраар хангагдаж, 4995 иргэн, 62 ААН, байгууллага нийт 4125 цагийн зөвлөх үйлчилгээг авч туршлага судлан мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна.

3. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 120 гаруй залуу бүртгүүлснээс 98 залуу хамрагдсан байна.

Уг арга хэмжээний хүрээнд ХХҮЕГ-аас албан ёсны эрхээ авсан Старт-ап Монголия ТББ-аар 3 өдрийн вакуумжуулсан сургалтыг зохион байгуулж, залуучуудын дунд 39 шинэ гарааны бизнесийн санаа гарч ирснээс 20 шилдэг бизнес эрхлэгч залуучуудын бүлэг хоорондоо уралдаж, сонгон шалгаруулалтаар 15 шилдэг гарааны бизнес эрхлэгч залуучуудын бүлэгт 150,0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг олгосон байна. Үүнд: барилгын засал чимэглэл, хоол хүргэлт, дугуй засвар, кофе бэйкерий зэрэг үйлчилгээний чиглэлээр 33.3 хувь, модон эдлэл, тахианы аж ахуй, чацаргана зэрэг үйлдвэрлэлийн чиглэлээр 20.0 хувь, дэрс ороох, оёдол, хавтангийн, мебелийн зэрэг хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 26.7 хувь, газар тариалан, сүү сүүн бүтээгдэхүүн, айраг савлах зэрэг ХАА-н чиглэлээр 20.0 хувь нь төсөл бичиж ирүүлсэн байна.

Дээрх төсөл хөтөлбөрийн үр дүнд 47 залуучууд байнгын ажлын байртай болсон байна.

Мөн аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд ШХА-аас хэрэгжүүлж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамтран “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв”-ийг 2019 оны 5-р сард байгуулжээ. Уг загвар төвийн тоног төхөөрөмж, ширээ хэрэгслийг төслөөс гаргаж, ХЭДСангийн хөрөнгөөр төвийн тохижилт засварыг хийж ашиглалтанд оруулсан байна. Уг загвар төвд гэрээгээр 2-3 залууг ажиллуулан цалинг аймгийн Дэд хөтөлбөрийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн байна.

4. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т 2019-2020 онд нийт 1258 иргэн хамрагдаж, 262 иргэн байнгын, 715 иргэн түр ажлын байраар хангагджээ. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 81 хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 230,0 сая төгрөгийн, 2020 онд 77 хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 240,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч 56 иргэнд бизнес эхлэх, төсөл төлөвлөгөө боловсруулах, гарааны бизнесийг хөгжүүлэх аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулснаар сургалтанд хамрагдагчид аж ахуй эрхлэх ур чадвар эзэмшсэн байна. Байгалийн хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт, тохижилт хийх, байгаль орчныг хамгаалах, мод тарих, усны даланг цэвэрлэх, засварлах үйл ажиллагааны хүрээнд 604 хүнийг 10 хоногийн түр ажлын байраар хангаж, ажилгүй иргэдийг орлоготой болоход дэмжлэг үзүүлсэн байна.

Баяннуур, Сагсай, Ногооннуур сумдад бүлгийн зохион байгуулалтаар ногоо тарих арга хэмжээг зохион байгуулснаар ажилгүй 56 иргэн 55 тн төмс, 0.8 тн хүнсний ногоо хураан авч өрхийн орлого нэмэгдсэн байна.

Зохион байгуулалттайгаар ажлын байр бий болгох арга хэмжээний хүрээнд 2019 онд Алтай, Алтанцөгц, Бугат, Баяннуур, Толбо, Сагсай, Цагааннуур, Улаанхус, Цэнгэл, Ногооннуур сумдын 10 бүлгийн 38 иргэнд 50,0 сая төгрөгийн, 2020 онд Бугат, Толбо, Сагсай, Цагааннуур, Цэнгэл, Ногооннуур сумдын 6 бүлгийн 18 иргэнд 28,8 сая төгрөгийн, нийт 78.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж байнгын ажлын байр, орлоготой болсон байна.

Мөн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй ажилгүй иргэдийг тогтмол ажлын байраар хангасан 9 ажил олгогчтой гэрээ байгуулан ажилгүй 19 иргэнийг байнгын ажлын байртай болгосон байна.

5. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 185 иргэн хамрагдаж, хөтөлбөрийн үр дүнд 114 байнгын ажлын байр бий болсон байна. Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 2019 онд 56 малчин өрхийг хамруулж 256,0 сая төгрөгийг зарцуулсны үр дүнд 112 байнгын ажлын байр бий болж, 56 өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн байна.

Дээрх арга хэмжээний хүрээнд малчин өрхүүдэд сумдын ЗДТГ-аас байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран газар дээр нь очиж, малчин өрхийн боловсруулсан төсөл, төлөвлөгөөний дагуу орон нутгийн малчдаас вакцинд хамрагдсан 3024 толгой малыг худалдан авч, хүлээлгэж өгсөн байна.

Малчдын туршлага судлах арга хэмжээг Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтарч 10 дугаар сард ОХУ-ын Горный-Алтай хотод зохион байгуулж, сум тус бүрээс 2-4, бүгд 26 малчныг хамруулж фермерийн аж ахуй, газар тариалангийн аж ахуйтай танилцуулан, туршлага судлуулсан байна. Мөн Менталики ХХК-тай хамтран малжуулах арга хэмжээнд хамрагдсан 46 залуу малчныг аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна.

6. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т 2019- 2020 онд нийт 172 иргэнийг хамруулж, 2019 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй 24 иргэнд 60,0 сая төгрөгийн, 2020 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч

хөгжлийн бэрхшээлтэй 31 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч буй 1 иргэнд 75,0 сая төгрөгийн 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг олгосноор нийт 61 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байнгын ажлын байраар хангагдсан байна.

Тайлант онуудад эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан, бичил бизнес эрхэлдэг, цаашид эрхлэх хүсэл сонирхолтой нийт 54 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна.

2020 оноос дэлхий нийтийг хамарсан цар тахал гарсантай холбоотой хөл хорио тогтоож, хил хаагдсан, бараа материалын үнэ өссөн зэргээс шалтгаалан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд, ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа явуулах, үр ашгаа дээшлүүлэх, улмаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байна.

Аудитын явцад цар тахлын улмаас хөл хорио тогтоосонтой холбоотой зарим төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан, төслийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх боломжгүй байсан болно.

II. Нийтлэг үйлчилгээний талаар:

1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ: 2019 онд Хөдөлмөрийн зах зээлд хөл тавьж байгаа залуучуудыг идэвхжүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн хэд хэдэн шинэлэг үйлчилгээ, арга хэрэгслийг нэвтрүүлэх зорилготой үе шаттай модуль сургалтыг 2 удаа зохион байгуулж 36 залуусыг хамруулсан байна.

Тайлант онуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг нийтдээ 2900 иргэнд үзүүлж, үүнээс ганцаарчилсан зөвлөгөөнд 1465, бүлгийн төрлөөр 1435 иргэн хамрагдсан байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгаа

Хүснэгт №8

№	Он	Ганцаарчилсан зөвлөгөө өгөх арга хэмжээнд хамрагдсан	Үүнээс /хувиар/		
			Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан	Ажилд зуучилсан	Бусад арга хэмжээнд хамрагдсан
1	2019	715	52.0	23.0	25.0
2	2020	750	65.0	25.0	10.0
	Дүн	1465	58.5	24.0	17.5

2019-2020 онуудад нийт 1465 иргэнд ганцаарчилсан үйлчилгээг үзүүлсэнээс зөвлөгөө мэдээлэл авсан иргэдийн 58.5 хувь нь ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдаж, 24.0 хувь нь ажилд зуучлагдаж, 17.5 хувь нь мэргэжлийн түр сургалт, нийтийг хамарсан ажилд хамрагдаж, түр болон байнгын ажлын байртай болсон байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг хэсэг бүлгээр зохион байгуулах арга хэмжээнд Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчид болон ажилгүй, ажил хайж байгаа иргэд, МСҮТ-ийн төгсөгчид зэрэг нийт 1435 иргэнийг хамруулсан байна.

2. Ажилд зуучлах үйлчилгээ: Ажилд зуучлах үйлчилгээний хүрээнд 2019-2020 онд 883 иргэнийг түр болон байнгын ажлын байранд зуучилсан байна.

Ажил зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгаа

Хүснэгт №9

№	Он	ААН, байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалга	Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан	Түр болон байнгын ажлын байранд зуучилсан	Үүнээс байнгын ажлын байранд зуучилсан /хувиар/
1	2019	1021	1116	1016	50.0
2	2020	790	820	750	59.0
	Дүн	1811	968	883	54.5

Эх сурвалж:?

Тайлант онуудын дүнгээр Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй 52 аж ахуйн нэгж байгууллагаас 1811 ажлын байрны захиалга ирүүлснийг ажил хайгч иргэдэд уламжилж, улмаар ажилд зуучлах үйлчилгээнд 968 иргэн хамрагдсанаас 883 иргэнийг өөрт нь тохирох түр болон байнгын ажлын байранд зуучилсан байна. Эдгээрийн 54.5 хувь нь байнгын ажлын байр байна.

Мөн тус арга хэмжээний хүрээнд 2020 онд Залуучуудын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор төрийн албанд орох хүсэлтэй залуучуудад зориулж “Төрийн албаны шалгалтыг хэрхэн амжилттай өгөх” талаар 3 өдрийн сургалтыг зохион байгуулж 20 иргэнийг хамруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг ААН, байгууллагуудад сурталчлах, зөвлөгөө, мэдээллээр хангах, шинэ болон сул ажлын байрны мэдээлэл авах, хамтран ажиллах, иргэдийг түр болон байнгын, оюутан залуусыг цагийн ажилд зуучлах зорилгоор “Ажлын байрыг дэмжье” сарын аяныг зохион байгуулсан байна.

Аудитын явцад 4.0 саяас дээш дүнтэй Ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 2019 онд хэрэгжсэн 1, 2020 онд хэрэгжсэн 4, Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслөөс 2020 онд хэрэгжсэн 5, бүгд 10 төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийг газар дээр нь шалгаж үзлээ. Үүнд:

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа зарим төсөл



2020 онд тус бүр 5.0 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн хоёр иргэний “талх, нарийн боов” цэх төсөл, 2019 онд нэг иргэний 4,0 сая төгрөгийн Мужааны цэх төслийн ажлын явц

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот зарим төслийн хэрэгжилт



Тус бүр 18.0 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн хоёр иргэний “Сүүний үхрийн аж ахуй”, Виртью ХХК-ны 18.0 сая төгрөгийн мах махан бүтээгдэхүүн боловсруулах төсөл

Дээрх төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд гэрээний хэрэгжилтийг хангаж, зээлийг хугацаанд төлж 3-4 хүнийг ажлын байртай болгосон байна. Төслүүдийн хэрэгжилтийг газар дээр нь шалгасан байдлаас үзэхэд зарим төсөл хөтөлбөрүүд зохих үр дүнгээ өгсөн байна.

Б.1.2. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх иргэн аж ахуйн нэгжид гэрээ байгуулсан боловч гэрээний үр дүнг тооцож, үнэлэх арга хэмжээ дутагдалтай байна

2019, 2020 онуудад төсөл хөтөлбөрт хамрагдаж үйл ажиллагаа явуулсан ААН-үүд гэрээгээ дүгнүүлж, ажлаа тайлагнасан байна. Харин төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох гэрээг 24-36 сарын хугацаатай байгуулсан, гэрээг дүгнэх хугацаа болоогүй байгаатай холбоотой энэ талаар аудитад баримт материал ирүүлээгүй болно.

2019 онд хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан мэргэжлийн болон давтан сургалтыг зохион байгуулсан МСҮТ, “Мөнх алтан хүлэг” ХХК-тай хийсэн сургалтын гэрээг дүгнэж, үр дүнг тооцон ажлын хэсэг акт үйлдэн баталгаажуулсан байна.

Өмнөх онуудад хэрэгжсэн 2019, 2020 онуудад гэрээний хугацаа дууссан төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг олгох гэрээг дүгнэж, үр дүнг тооцсон эсэх талаар ирүүлсэн баримт материалыг шалгаж үзэхэд гэрээг дүгнэж акт үйлдсэн боловч энэ нь бүрэн бус зарим гэрээг дүгнээгүй, актанд зөвхөн дэмжлэгийн эргэн төлөлттэй холбоотой дүгнэлтийг бичсэн боловч төслийн үр дүн, үр өгөөжийг гэрээний заалт бүрээр бүрэн үнэлж дүгнэх асуудал дутагдалтай байна.

Аудитын дүнгээр ХХҮГ-т төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдтэй байгуулсан гэрээг бүрэн дүгнэж, төслийн үр дүнг тооцож баримтжуулж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Б.2. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Б.2.1. ХЭДСангийн батлагдсан төсвийг хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлээгүй байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд 2019 онд 1388,6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас 1354,0 сая төгрөгийн санхүүжилт авч 34,6 сая төгрөгийн, 2020 онд 750,6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас 583,0 сая төгрөгийн санхүүжилт авч 167,6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

2020 онд цар тахлын улмаас улсын төсвийн орлого бүрдүүлэлт хүндэрсэнээс улсын төсвөөс олгох санхүүжилтийг бүрэн олгоогүй байна. Үүнээс шалтгаалан хувь хүмүүст өгөх зарим санхүүгийн дэмжлэг болон түрээсийн хөнгөлөлтийн 28,4 сая төгрөгийн, ажил байрны дэмжих хөтөлбөрийн ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд гэрээний дагуу олгох 56,5 сая төгрөгийн, бусад ажил үйлчилгээний зардлуудыг жилийн эцэст өглөгөөр харуулж 2021 оны эхний хагас жилд нөхөн санхүүжүүлж барагдуулсан байна.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 2019 онд 289,1 сая, 2020 онд 260,3 сая, ХБИ ажиллуулаагүйн орлогоос 2019 онд 7,2 сая, 2020 онд 7,6 сая төгрөг, нийтдээ 599,9 сая төгрөгийг журмын дагуу төсөвт төвлөрүүлсэн байна.

Б.2.2. Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 онд батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөрүүдийг батлах тухай” 01 тоот тогтоолоор батлагдсан төсөл хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулах, олон нийтэд мэдээлэх, сурталчилахтай холбоотой заалтуудыг мөрдлөгө болгон ажилласан байна. Тухайлбал:

➤ Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг малжуулах арга хэмжээ, ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хөгжүүлэх хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг зэрэг төсөл хөтөлбөрүүдийг 2019, 2020 онуудад тогтоолын хавсралтын холбогдох заалтуудын дагуу 21 хоног орон нутгийн радио телевиз, байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсаар зарлан мэдээлж ил тод байдлыг хангаж мэдээлэл, зөвлөгөө өгч, иргэдийн хүсэлт холбогдох материалыг хүлээн авч ажилласан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Халамж үйлчилгээний газрын даргын 2019 оны А/13, А/18, А/19, А/20 тоот, 2020 оны А/05, А/06, А/08, А/09, А/10 тоот, тушаалуудаар 2019, 2020 оны хэрэгжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулах, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих зорилго бүхий ажлын хэсгүүдийг 5-7 гишүүнтэй баталж ажилласан байна.

Төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулж зохион байгуулахдаа 3 үе шаттай буюу ирүүлсэн төслүүдэд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг нягтлах, шаардлага хангасан төслүүдийн үйл ажиллагаатай танилцах, шалгарсан төслүүдийг хөтөлбөр тус бүрийн томилогдсон ажлын хэсэг иргэдийн ажлын байртай газар дээр нь танилцаж дүгнэлт гаргасны дагуу сонгон шалгаруулж, санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

ХЭДС-гаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгт 2019 онд 6 төсөл, хөтөлбөрт 495 иргэнээс хүсэлт ирүүлснээс 233 иргэнийг, 2020 онд 3 төсөл арга хэмжээнд 232 иргэнээс хүсэлт ирүүлснээс 124 иргэнийг зохих журмын дагуу шалгаруулсан байна.

Хүснэгт № 10

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөрийн нэр	2019 он	2020 он
-----	-----------------	---------	---------

		Хүсэлт гаргасан хүний тоо	Хөтөлбөрт хамарсан хүний тоо	Олгосон санхүүгийн дэмжлэгийн дүн	Хүсэлт гаргасан хүний тоо	Хөтөлбөрт хамарсан хүний тоо	Олгосон санхүүгийн дэмжлэгийн дүн
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	207	81	230,000.0	128	77	240,000.0
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	70	23	60,000.0	78	32	75,000.0
3	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	62	56	256,000.0			
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	120	47	150,000.0			
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	20	20	27,000.0	26	15	30,000.0
6	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	16	6	100,000.0			
	Дүн	495	233	823,000.0	232	124	345,000.0

/Эх сурвалж: аймгийн ХХҮГ-ын санхүүгийн холбогдох материал/

Хүснэгтээс үзэхэд 2020 онд 124 иргэнд 345,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь өмнөх оноос 109 иргэн буюу 478,0 сая төгрөгөөр бага байна. Энэ нь 2020 онд төсвийн тодотголоор зарим төсөл хөтөлбөрүүд хасагдсантай холбоотой байна.

Б.2.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тус аймагт 2019 онд батлагдсан 18 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний зардалд 1388,6 сая төгрөг, 2020 онд батлагдсан 15 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний зардалд 758,2 сая төгрөг тус тус төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2019 онд 1339,0 сая төгрөгийн, 2020 онд 587,6 сая төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан байна. /2019, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг дэлгэрэнгүй задаргааг хавсралт 1-ээр харуулсан ба нэгтгэлийг хүснэгтээр харуулахад:

Хүснэгт № 11

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2019 он			2020 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарлагын дүн	1,388,581.0	1,339,005.9	49,575.1	758,173.7	587,592.4	170,581.3

/Эх сурвалж: аймгийн ХХҮГазрын санхүүгийн холбогдох материал/

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөрүүдийг батлах тухай” 01 тоот тогтоол болон аймгийн ХХҮГ-ын даргын баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хөдөө сумдад хэрэгжүүлэх ажлын удирдамж”-ын дагуу хэрэгжүүлсэн 6 хөтөлбөр, 1 төслийн хэрэгжилтийг шалгаж үзлээ. Үүнд:

1.Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн талаар:

Иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад хамруулж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2019 онд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай ажил олоход хүндрэлтэй иргэд

хамрагдсан ба 35,7 сая төгрөг зарцуулсан байна. Харин 2020 онд тус хөтөлбөр хэрэгжээгүй байна.

2019 онд хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн дэлгэрэнгүй задаргааг хавсралт 2-оор харуулсан ба нэгтгэлийг хүснэгтээр харуулахад

Хүснэгт №12

/Мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 оны Дүн	216	39,230.0	296	35,661.0	(80)	3,569.0

/Эх сурвалж: аймгийн ХХҮГ-ын санхүүгийн холбогдох материалаас/

Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй 120 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулж 5,4 сая төгрөг зарцуулсан байна.

“Күмис ине” ХХК, “Алтайн алтан орд” ХХК-уудтай үйлдвэрийн дадлага явуулах гэрээ байгуулж, ажилгүй 40 иргэнийг оёдолчин, бетон арматурчин мэргэжлээр үйлдвэр дээр дадлагажуулан сургаж 17,5 сая төгрөг зарцуулсан байна.

Иргэний суралцах мэргэжлийн чиглэл, хүсэлтийг харгалзан тогооч мэргэжлээр 46, худалдагч, касс, нярав мэргэжлээр 43, мужаан мэргэжлээр 15, гагнуурчин мэргэжлээр 15, үсчин мэргэжлээр 17, бүгд 136 иргэнийг түр сургалтад хамруулан нийт 12,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн талаар:

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил, хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад, суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэхэд чиглэгдсэн ажлын байрыг дэмжих хөтөлбөр 8 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээс 2019, 2020 онуудад жил бүр 7 арга хэмжээг зохих журмын дагуу зохион байгуулж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолын хоёр дугаар хавсралтаар баталсан эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулах, ажлын байрны болон түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, ажил олгогчийг дэмжих арга хэмжээ зохион байгуулах, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ, Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалахад заасан холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

2019, 2020 онуудад ажлын байрыг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн задаргааг хавсралт 3-аар харуулсан ба нэгтгэлийг хүснэгтээр харуулахад:

Хүснэгт №13

мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 оны Дүн	700	526,600.0	617	523,240.0	83	3,360.0

2020 оны Дүн	440	514,506.5	566	379,965.3	(126)	134,541.2
--------------	-----	-----------	-----	-----------	-------	-----------

/Эх сурвалж: аймгийн ХХҮГ-ын санхүүгийн холбогдох материалаас/

Тус хөтөлбөрт 2019 онд төлөвлөгдсөн санхүүгийн дэмжлэг, борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт, ажил олгогчид олгох дэмжлэг, нийтийг хамарсан ажил, зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ, бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах зэрэг арга хэмжээнүүдэд батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан боловч аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалтын төсвөөс 3,4 сая төгрөг зарцуулагдаагүй хэмнэгдсэн байна. Энэ нь сургалтын хоногийг 5 хүртэл хоногоор зохион байгуулахаар төсөвт тусгагддаг боловч орон нутагт ихэнх сургалт 3 хоногоор зохион байгуулагдсантай холбоотой байна.

Харин 2020 онд Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт, Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээнүүдийн батлагдсан төсвийг бүрэн зарцуулж, бусад арга хэмжээнүүд төсөв дутуу ирсэнээс 5,5-42,5 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй байна. Энэ нь 2020 онд санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

2020 оны эцэст санхүүгийн дэмжлэг, Ажил олгогчид олгох дэмжлэг, Нийтийг хамарсан ажил, Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ, Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт зэрэг арга хэмжээнүүдийн дутуу ирсэн санхүүжилтийн хэмжээгээр тайланд өглөгөөр тусгасан ба 2021 онд эхний хагас жилд 89,0 сая төгрөгийг олгосон байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 2019-2020 оны хэрэгжилтийн талаар товч дурьдвал:

- 2019 онд 230.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

Төсөл сонгон шалгаруулалтын үеэр ажлын байрт танилцсан байдал:



- 2019 онд 13 ажил олгогчид 83,2 сая төгрөгийн санхүүгийн урамшуулал олгожээ.
- Байгалийн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт, тохижилт хийх, байгаль орчныг хамгаалах, мод тарих, усны даланг цэвэрлэх, засварлах, нийтийн эзэмшлийн зам засах үйл ажиллагааны хүрээнд нутгийн захиргааны байгууллага, аж ахуй нэгжээс ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж 2019 онд 385 хүнийг 10 хүртэл хоногийн хугацаанд түр ажлын байраар хангаж, ажилгүй иргэдийг орлогоор дэмжсэн арга хэмжээнд нийт 111,9 сая төгрөг, 2020 онд 232 хүнийг 10 хүртэл хоногийн хугацаанд түр ажлын байраар хангаж, ажилгүй иргэдийг орлогоор дэмжсэн арга хэмжээнд нийт 56,5 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

- Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг Баяннуур, Сагсай, Ногооннуур сумдад зохион байгуулж 56 ажилгүй иргэн бүлгийн зохион байгуулалттайгаар оролцож, уг арга хэмжээнд 30,0 сая төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/83 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийн 2.2.7.3-т “арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг иргэдийн цалин, урамшуулал, хоолны зардалд бус хүнсний ногоо тариалахтай холбоотой үр бордоо, бага оврын багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах хашаа, хайс, хүлэмж барих, худаг гаргах, амралтын гэр, байр барих зэрэг болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, бусад холбогдох үйл ажиллагааны зардалд зарцуулна” гэж заасныг мөрдлөг болгон ажилласан байна.

Журмын дагуу сумуудад бүлгийн хүнсний ногоо тариалах арга хэмжээнд шаардлагатай багана төмөр, өргөст төмөр, хүлэмж, усны насос, усны шланг зэрэг материалыг худалдан авч сумуудын Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт хүлээлгэн өгсөн боловч орлого авч бүртгэлд тусгагдаагүй байна.

Аудитын явцад энэ талаар тодруулж үэхэд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоол болон аймгийн ХХҮГазрын дарга, сумын Засаг дарга, бүлгийн ахлагчтай байгуулсан “Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээний гэрээ”-нд хөрөнгийг бүртгэх талаар ямар нэгэн заалт байхгүй байна.

Мөн ХХҮЕГ-ын даргын тушаалаар батлагдаж ирсэн загвар маягтыг мөрдөж Бүлгүүдэд байгуулсан “Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээний гэрээ”-ний 2.3-т “А талын үүргийг хөтөлбөр хэрэгжих хугацаанд В талын хүнсний ногооны тариалалт, ургалтын явцад анхаарал тавьж, төсөл үр дүнтэй хэрэгжихэд байнгын хяналт тавьж ажиллана” гэсэн заалт тусгасан боловч тус гэрээний 1.4-т “энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа нь гэрээг байгуулснаас хойш 6 сарын дараа В тал үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлснээр дуусгавар болно” гэж заасан нь холбогдох эрх зүйн актууд харилцан уялдаагүй байгааг харуулж байна.

- Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээг 2020 онд сумуудаас хэрэгжүүлэхээр ирүүлсэн амжиргаа дэмжих зөвлөлийн хурлын тогтоол, холбогдох журмуудыг мөрдлөг болгон ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж Бугат, Толбо, Сагсай, Цагааннуур, Цэнгэл, Ногооннуур сумын 6 бүлгийн 18 иргэнд нийтдээ 28,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн байна.

Тус арга хэмжээний 2019 оны баримт материалыг хуулийн байгууллагад шалгагдаж байгаа тул аудитын явцад ирүүлээгүй ба аймгийн Прокурорын газрын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Хэрэг бүртгэлийн хэргийг хаах тухай” хэрэгсэхгүй болгосон 46 тоот тогтоол гарсан байна.

Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд зориулан тоног төхөөрөмж хүлээлгэж өгсөн зарим үйл ажиллагааг харуулав:



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д "Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь бүлгийн ажлын төлөвлөгөө, зардал, хөрөнгийн тооцоо, гэрээг, үндэслэн бүлэг тус бүрт 5.0 хүртэл сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийн нэг удаагийн буцалтгүй дэмжлэгийг олгоно" гэж заасны дагуу тоног төхөөрөмжийг нэг удаагийн буцалтгүй дэмжлэгээр олгосон байна. Үүнд:

- Бугат сумын бүлэгт "Нэхий элдэх, ноос самнах машин" 5,0 сая,
- Толбо сумын "Хашаа хороо засварлах тоног төхөөрөмж" 4,2 сая,
- Сагсай сумын "Хашаа хороо засварлах тоног төхөөрөмж" 4,7 сая,
- Цагааннуурт "Сүү цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж 5,0 сая,
- Цэнгэлд хадлан "тэжээл бэлтгэх тоног төхөөрөмж" 5,0 сая
- Ногооннуурд "хадлан тэжээл бэлтгэх тоног төхөөрөмж" 4,9 сая төгрөг

➤ Ажил олгогчид олгох дэмжлэгт бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил олоход хүндрэлтэй ажилгүй иргэдийг тогтмол ажлын байраар хангасан 6 ажил олгогчтой шинээр гэрээ байгуулан ажилгүй 2019 онд 7, 2020 онд 4 иргэнийг байнгын ажлын байраар ханган ажилласан 2 аж ахуйн нэгж байгууллагын гэрээг дүгнэн 19,1 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ үйл ажиллагаанд тус сангаас 2019 онд 523,2 сая төгрөг, 2020 онд 379,9 сая төгрөг, хоёр жилд нийтдээ 9036,2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 15 багт нийт 150,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй, 36 сарын хугацаатай санхүүгийн дэмжлэгийг олгосон байна. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих старт аппын арга хэмжээ сургалт зохион байгуулахад 10,0 сая төгрөг, борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээнд 17,3 сая төгрөг, аж ахуй эрхлэх үр чадвар олгох сургалтын зардалд 0,4 сая төгрөгийг зарцуулсан байна. Харин 2020 онд энэ хөтөлбөр хэрэгжээгүй байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн 2019, 2020 онуудын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн задаргааг хавсралт 4-ээр харуулсан ба нийт нэгтгэлийг хүснэгтээр харуулахад

Хүснэгт №14

/Мянган төгрөгөөр

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэсэн зардал	Зөрүү
----	----------	------------	--------------------	-------

		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Дүн	117	180,340.0	45	177,715.0	72	2,625.0
2020 он	Дүн	440	3,380.0	566	-	2	3,380.0

/Эх сурвалж: аймгийн ХХҮГазрын санхүүгийн холбогдох материалаас/

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулахаар 2019 оны 04 сараас залуучуудад зарлан мэдээлсний үндсэн дээр аймгийн хэмжээнд 120-иод залуучууд бүртгүүлснээс тус старт апп сургалтын арга хэмжээнд 98 залуучууд хамрагджээ.

Уг арга хэмжээний хүрээнд ХХҮЕГ-аас албан ёсны эрхээ авсан Старт-ап Монголия ТББ-аар 3 өдрийн вакуумжуулсан сургалтыг зохион байгуулж, залуучуудын дунд 39 шинэ гарааны бизнесийн санаа гарч ирснээс 20 шилдэг бизнес эрхлэгч залуучуудын бүлэг хоорондоо уралдаж, сонгон шалгаруулалтаар 15 шилдэг гарааны бизнес эрхлэгч залуучуудын бүлэгт 150,0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу олгосон байна.

Мөн аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Шведцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамтран “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв”-ийг 2019 оны 5-р сард байгуулжээ. Уг загвар төвийн тоног төхөөрөмж, ширээ хэрэгслийг төслөөс гаргасан бол төвийн тохижилтонд сангаас зардал гаргаж засвар хийж ашиглалтанд оруулсан. Уг загвар төвд гэрээгээр 2-3 залууг ажиллуулан цалинг аймгийн Дэд хөтөлбөрийн хүрээнд Орон нутгийг хөгжүүлэх сангаас батлуулан ажиллуулсан байна.

4.Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Малчдын хөдөлмөрийг дэмжих замаар цөөн малтай болон малгүй иргэдийг ажлын байртай болгох арга хэмжээнд хамрагдах малчин өрхийн тоог сумуудаас ирүүлсэн саналыг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн Цагааннуур тосгон, Булган, Бугат, Буянт, Толбо, Улаанхус, Цэнгэл сумдад хэрэгжүүлэхээр баталсан байна.

2019 онд малчин хөдөлмөр эрхлэх хөтөлбөрийн гурван арга хэмжээнд 305,5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр 278,8 сая төгрөг зарцуулж, 26,7 сая төгрөг хэмнэгдсэн байна. Харин 2020 онд Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэхээр төсөв төлөвлөгдөөгүй байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн задаргааг хавсралт 5-аар харуулсан ба нийт нэгтгэлийг хүснэгтээр харуулахад

Хүснэгт №15

/Мянган төгрөгөөр


Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 оны Дүн	239	305,500.0	66	278,807.2	173	26,692.8

/Эх сурвалжийг: аймгийн ХХҮГазрын санхүүгийн холбогдох материалаас/

Сумдаас хөтөлбөрийн тавигдах шаардлагыг хангасан малчин өрхийг сумдын Амьжиргааг дэмжих зөвлөлтэй хамтран сонгон шалгаруулж, Цагааннуур тосгоны 4,

Булган 6, Бугат 12, Буянт 8, Толбо 7, Улаанхус 9, Цэнгэл 10, бүгд 56 малчин өрхийг хамруулж, 256,0 сая төгрөг зарцуулжээ.

Малчин өрхүүдэд сумдын Засаг даргын тамгын газраас байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран газар дээр нь очиж, малчин өрхийн боловсруулсан төслийн дагуу орон нутгийн малчдаас вакцинд хамрагдсан, эрүүл, залуу 3024 толгой малыг худалдан авч өгсөн байна.



Малчдад мал хүлээлгэж өгч байгаа байдал

Малчдын туршлага судлах арга хэмжээг Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтарч 10 дугаар сард ОХУ-ын Горный-Алтай хотод зохион байгуулж, сум тус бүрээс 2-4, бүгд 26 малчин хамрагдсан байна. Дэд шатны байгууллагын шийдвэр болон аймгийн ХЭДСангийн зөвлөлийн хурлын шийдвэрүүдийг үндэслэн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр:

ХБИ-ийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамаруулах, урамшуулал санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 2019 онд 7 арга хэмжээнд 97,3 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 83,8 сая төгрөг, 2020 онд 4 арга хэмжээнд 100,9 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 87,5 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн задаргааг хавсралт 6-аар харуулсан ба нийт нэгтгэлийг хүснэгтээр харуулахад:

Үзүүлэлт	/Мянган төгрөг/					
	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 оны Дүн	142	97,340.0	72	83,811.7	70	13,528.3
2020 оны Дүн	440	100,967.5	566	87,477.5	(29)	13,490.0

/Эх сурвалж: аймгийн ХХҮГазрын санхүүгийн холбогдох материалаас/

2019 онд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд Өлгий сумаас 47, хөдөө сумдаас 23 иргэн бүртгүүлснээс тавигдах шаардлагыг хангасан хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй 23 иргэнд 2,0-5,0 хүртэл сая төгрөгөөр нийтдээ 60,0 сая төгрөгийг 100 хувийн эргэн төлөх нөхцөлтэй олгосон байна.

Харин 2020 онд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга Өлгий сумаас 51, хөдөө сумдаас 27 иргэн бүртгүүлсэн ба төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр тавигдах шаардлагыг хангасан хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй 31 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч буй 1 иргэн, бүгд 32 иргэнд 1,5-4,5 сая төгрөгөөр нийтдээ 75,0 сая төгрөгийг ХЭҮЗөвлөлийн 2020 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний нэмэлт, өөрчлөлтүүд”-ийн 4 зүйлийн 4.3-т заасны дагуу 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан болон бичил бизнес эрхэлдэг, цаашид эрхлэх хүсэл сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй 2019 онд 32, 2020 онд 22, бүгд 54 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний сургалтад хамруулсан байна.

2020 онд хөгжлийн бэрхшээлтэй 24 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний сургалтад хамруулсан байна.

6.Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг хрэгжүүлэхэд 2019 онд 2 арга хэмжээнд 41,3 сая төгрөг, 2020 онд 2 арга хэмжээнд 41,3 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн задаргааг хавсралт 7-оор харуулсан ба нийт нэгтгэлийг хүснэгтээр харуулахад:

Хүснэгт №17		/мянган төгрөг/					
Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Дүн	26	41,280.0	39	41,280.0	(13)	-
2020 он	Дүн	12	35,200.0	15	30,000.0	-	5,200.0

/Эх сурвалж: аймгийн ХХҮГазрын санхүүгийн холбогдох материалаас/

Ахмад мэргэжилтнүүдийн мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох зорилгоор боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, төрийн захиргааны чиглэлээр ахмадын зөвлөх үйлчилгээг ахмад мэргэжилтэн болон ахмад мэргэжилтнүүдийн багт ил тод зарлан ажлын хэсгийн шалгаруулсан 2019 онд 19 ахмад мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажиллаж 12,5 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Хүүхэд хамгаалагч туршилтын төслийн хүрээнд 4 ахмад мэргэжилтэн аймгийн төвийн 13 сургуультай хамтран ажиллаж хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эерэг аргаар хүмүүжүүлэх, ёс суртахууныг гэр бүлд нь төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж хүүхэд хамгааллын урамшуулалд 1,8 сая төгрөг олгосон байна.

Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй өөрийн амьдралын явцад олж авсан, мэдлэг, туршлагадаа тулгуурлан өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор бичсэн ахмадын төслийг төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр 2019 онд 20, 2020 онд 15 ахмад настанд нийтдээ 57,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.



Ахмад настануудын ажлын байр

7.Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл: Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн гол зорилго нь Бичил бизнес эрхлэгчид орон нутгийнхаа онцлогт нийцүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь хөнгөлөлттэй зээл олгож ажлын байр бий болгох, тогтвортой орлоготой болгохыг дэмжих зорилготойгоор эргэн төлөгдөх, хүүгүй, барьцаагүй, 36 сарын хугацаатай итгэлийн зээлийн хэлбэрээр санхүүжилтийг олгоход чиглэгдэнэ.

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд 2019 онд 100,0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 6 иргэн аж ахуйн нэгжид 100,0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгээр олгосон байна. Харин 2020 онд Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд хөрөнгө төлөвлөгдөөгүй байна.

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн задаргааг хавсралт 8-аар харуулсан ба нийт нэгтгэлийг хүснэгтээр харуулахад:

Хүснэгт №18					/Мянган төгрөг/	
Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 оны Дүн	-	108,500.0	6	108,500.0	-	-

/Эх сурвалж: аймгийн ХХҮГазрын санхүүгийн холбогдох материалаас/

Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд 16 төсөл ирүүлснээс таван хүний бүрэлдхүүнтэй ажлын хэсэг шаардлага хангасан 6 төслийг шалгаруулан 10,0-19,0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэний дагуу эргэн төлөх нөхцөлтэй хүүгүй зээл олгосон байна.

Аудитын явцад олгогдсон 6 төслийн хэрэгжилтийг газар дээр нь очиж үзэхэд бүгд үйл ажиллагаа явуулж байгаа ба цар тахал ковид 19 өвчин гарсантай холбоотой 2019-2020 онуудад үйл ажиллагаа хэвийн явуулж чадахгүй байгаа талаар тайлбарлаж байв.Тус төслийн 5 иргэн аж ахуйн нэгжийн төслийн хэрэгжилтийг газар дээр нь очиж үзсэн ба тайлангийн Б.1-т хэсэгт дурьдсан болно.

Аудитын явцад Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд хамрагдсан 10,0-19,0 сая төгрөгийн дүнтэй нийтдээ 100,0 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг шалгаж үзэхэд 2020 оны 12 сарын 31-ний байдлаар төлж дуусгах ёстой хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлж барагдуулахаар болов.

Мөн 2018 онд Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд хамрагдсан 15,0-45,0 сая төгрөгийн нийтдээ 100,0 сая төгрөгийн зээлийг эргэн төлөх нөхцөлтэйгээр авсан 3 иргэн, аж ахуйн нэгжийн төлөх хугацаа хэтэрсэн ба холбогдох 2 иргэн, аж ахуйн нэгжид уулзан хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэхээр болов. Нэг иргэн тодорхой шалтгаанаар ирж уулзаж чадаагүй байна.

Тус төслийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлагад өгсөн ба зээлийн эргэн төлөлтийн дэлгэрэнгүй мэдээллийг А.2.2-р хэсэгт дурьдав.

2020 онд 31 иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөлд Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн талаар зөвлөгөө өгч ажилласан байна.

8.ХЭ-ийг дэмжих арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээ: 2019 онд 11 хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний зардалд 89,8 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 89,8 сая төгрөг зарцуулсан байна.

2020 онд 11 хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний зардалд 96,6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 84,3 сая төгрөг гарч 87.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

2019, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн задаргааг хавсралт 9-ээр харуулсан ба нийт нэгтгэлийг хүснэгтээр харуулахад:

Хүснэгт №19

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 оны Дүн	3,101	89,791.0	3,277	89,791.0	(176)	
2020 оны Дүн	2,726	96,590.2	1,330	84,283.1	1,396	12,307.1

/Эх сурвалжийг: аймгийн ХХҮГазрын санхүүгийн холбогдох материалаас/

➤ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд 2019 онд 2117, 2020 онд 823 иргэн, бүлгийн сургалт зохион байгуулж, 2019 онд 16,8 сая, 2020 онд 8,9 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 179 дүгээр төлбөрийн хүсэлтээр “Ажлын чиг баримжаа олгох” зардлаас нэг иргэнд “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт 0,4 сая төгрөгийг олгосон зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

➤ Ажилд зуучлах үйлчилгээнд 2019 онд 1160 иргэн, 2020 онд 507 иргэн хамрагдсанаас түр болон байнгын ажлын байранд зуучилж, 2019 онд 11,7 сая, 2020 онд 11,2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аудитын явцад 2019 онд “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ”-ий батлагдсан төсвөөс тайлант оны “Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй олгох санхүүгийн дэмжлэг”-т материал ирүүлсэн ахмадуудаас Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн сонгон шалгаруулж баталсан жагсаалтад ороогүй нэг иргэнд 0,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлсэн нэг ахмад настанд

журам зөрчиж зардлын дээд хэмжээнээс 40 цаг буюу 0,1 сая төгрөгөөр илүү урамшуулал олгосон зэрэг нийтдээ 1,0 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрсэн.

Аудитын дүнгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийн зардлыг зориулалтын дагуу зарцуулах, батлагдсан төсвийн хүрээнд, ажлын хэсгийн дүгнэлтээр шалгарсан иргэдэд санхүүгийн дэмжлэгийг олгох талаар албан шаардлага өгөв.

БҮЛЭГ 3. В. САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА

В.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналт үр нөлөөтэй байна

В.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээллийн бааз бүрдүүлсэн байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээллийн баазыг 2016 оноос эхлэн бүрдүүлж “Гөү-Окей” ХХКомпаниас албан ёсны зөвшөөрөл бүхий AXPLORER 3.52 гэсэн санхүүгийн программтай болсон байна. Программд жил бүр санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн мэдээллийг нэгдсэн баазд оруулж, программд шинэчлэн баяжуулалт хийсэн байна. Мэдээ тайланг программаар боловсруулан ХХҮЕГазрын “ТАЛСТ” системд улирал, хагас, бүтэн жилээр илгэж баталгаажуулдаг байна.

В.1.2. Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн салбар зөвлөлөөс дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна

Зөвлөлийн хурлыг 6 удаа 80-90 хувийн ирцтэй хийж, “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.3-т “Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд хуралдааныг гишүүдийн дийлэнх буюу 75 хувиас доошгүй хувь нь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно” гэсэн заалтыг баримталж ажилласан байна. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөс 6 удаа хуралдаж хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн орлого, зарлагын байдал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон үйлчилгээний хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж танилцсан байна.

В.1.3. Сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт зохих түвшинд хэрэгжсэн байна

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу Алтанцөгц, Баяннуур, Дэлүүн, Толбо, Бугат, Сагсай, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумууд болон Цагааннуур тосгонд 2017-2020 онуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнтэй газар дээр нь очиж танилцан хяналт хийж, зөвлөгөө өгч, санхүүгийн дэмжлэг авсан эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, төлөхгүй байгаа иргэдтэй уулзаж төлбөр барагдуулах талаар мэдэгдэх хуудас өгч, холбогдох хууль, журмыг танилцуулж, зохих арга хэмжээнүүдийг авч ажилласан байна.

2019 онд Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний зүгээс Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрх зүйн баримттай танилцан, зарим мэргэжилтнүүдэд үйл ажиллагаа явуулахад холбогдолтой хууль, журмын зарим заалтад тайлбар өгч, мэдээллээр хангаж ажилласан ба ажилтан, албан хаагчдын өдөр тутам, сар, улирал, хагас, бүтэн жилээр дээд байгууллагуудад гаргаж өгөх тайлангийн жагсаалтыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Сангийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангах тал дээр мэргэжилтнүүдэд тухай бүр зөвлөгөө өгч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй гэрээ байгуулан ажилласан байна.

В.2. ХЭДСангийн эргэн төлөлтөд тавих хяналтын үр нөлөө бага байна

В.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтөд тавих хяналтын үр нөлөө бага байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого нь улсын төсвийн хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллага гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөр, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгийн эх үүсвэрээс бүрддэг байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг ХНХЯам, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс хуваарилалт хийн баталж санхүүжилтийг олгодог баймгийн ХХҮГ-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн төлөвлөлтөд төсвийн төсөөллийг хийж хүргүүлдэг байна.

Аж ахуйн нэгж, байгууллага гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөрийн орлого нь тус газрын дансаар дамждаггүй, шууд ХХҮЕГ-т төвлөрдөг байна. Аймгийн ХХҮГ-аас тус арга хэмжээтэй холбоотой ХХҮЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу тухайн ААН, байгууллагад хяналтыг хэрэгжүүлж, ажлын тайланг хүргүүлсэн байна.

ХХҮГ-аас 2019 онд ХНХЯ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу гадаадаас ажиллах хүч авч ажиллуулж байгаа 9 аж ахуйн нэгж, байгууллага, 2020 онд 8 аж ахуйн нэгж, байгууллагад газар дээр нь очиж хяналт шалгалт хийж, ажлын тайлан, холбогдох судалгааг ХНХЯаманд хүргүүлсэн байна.

ХХҮГ-аас ирүүлсэн судалгаанаас үзэхэд аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 31 төсвийн байгууллагад 74 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 2020 оны байдлаар 24 аж ахуйн нэгж байгууллагад 72 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна.

2020 оны байдлаар 5 аж ахуйн нэгж байгууллага хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлдөг ба хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулдаггүй 16 аж ахуйн нэгж байгууллага тухайн төлбөрийг төлдөггүй гэсэн мэдээллийг ирүүлсэн байна. Үүнээс үзэхэд Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй, аж ахуйн нэгж байгууллагууд хуулийг хэрэгжүүлж ажилладаггүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийн орлоготой холбоотой ХХҮГ-ын мэргэжилтнүүд аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчтай хамтран 2019-2020 онд нийт 12 аж ахуйн нэгж байгууллагад хяналт, шалгалтыг хэрэгжүүлж, 2019 онд 6 аж ахуйн нэгж байгууллагаас 7,3 сая төгрөгийг, 2020 онд 6 аж ахуйн нэгж, байгууллагаас 7,6 сая төгрөгийн төлбөрийг төлүүлэн хөдөлмөр эрхлэлтийн дэд санд төвлөрүүлсэн байна.

ХХҮГ-ын мэргэжилтнүүд “Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагын төлбөр тооцоонд хяналтыг хэрэгжүүлж, эрх зүйн акт гаргах эрх хэмжээ байхгүй тул орлогын бүрдүүлэлтийг хангах, арга хэмжээ авах боломжгүй байдаг ба МХГ-ын байцаагчтай хамтран хяналтыг хэрэгжүүлдэг” гэсэн тайлбарыг өгсөн байна.

Аудитын дүнгээр ХХҮГ-т хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулахгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг төлүүлэх, хуулийн талаар сургалт

сурталчилгаа хийх, хяналтыг хэрэгжүүлж, орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөмж хүргүүлэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас сүүлийн 5 жил хэрэгжсэн 6 төсөл хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 2442,6 сая төгрөгийг олгосон ба үүнээс 2021 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар 504,7 сая төгрөгийг зээл барагдаж, 663,2 сая төгрөгийн зээл хугацаа болоогүй, 14,5 сая төгрөгийн зээл найдваргүй авлагаар бүртгэгдэж, 441 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчийн 729,3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.

ХХҮГ-аас хугацаа хэтрэлттэй явж байгаа зээлдэгчид хууль журмыг танилцуулан эргэн төлөлтийг хугацаанд нь төлөх талаар сануулах, газар дээр нь очиж шаардах, мэдэгдэх хуудас өгөх, гэрээний хугацаа дуусвар болсон үед төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

2021 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар 107 зээлдэгчтэй холбоотой 142,9 сая төгрөгийн төлбөр Шүүхийн шатанд шийдвэрлэгдэхээр хүргүүлсэн байгаа гэсэн судалгааг ирүүлсэн байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал гарсантай холбоотой хөл хорио тогтоож, хил хаагдсан, бараа материалын үнэ өссөн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд, ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа явуулах, улмаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нөлөөлсөн боловч ХХҮГ-аас санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн орлого бүрдүүлэлтэд тавих хяналтын үр нөлөө бага байна.

В.2.2. 2019, 2020 онуудад хэрэгжсэн хөтөлбөрийн явцын хяналтыг байгууллагын дотоод хяналтын зүгээс бүрэн хэрэгжүүлээгүй, дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар тайлагнаагүй байна

Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсээс 2019 онд Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд МХНМХолбоотой хамтран зохион байгуулсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын явцад хяналтыг хэрэгжүүлж, санхүүжилтийг олгосон байна. Мэргэжлийн болон давтан сургалтаар аймгийн МСҮТ болон “Мөнх алтан хүлэг” ХХК-тай хамтран зохион байгуулсан тогооч, касс нярав, үсчин, гагнуурчин, мужааны сургалтын явцын хяналтыг 2 удаа, үйлдвэрлэл дээр сургалтаар “Күмис ине” ХХК, “Алтайн алтан орд” ХХК-ий зохион байгуулсан гар урлал, цахилгаанчин, гагнуурчны сургалтуудад мөн явцын 2 удаагийн хяналтыг хийж, хяналтын хуудас хөтлөн, зөвлөмжийг өгч ажилласан байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан иргэдтэй эргэх холбоо тогтоож улиралд 1 удаа болон зарим иргэдийн ажлын байранд давхардсан тоогоор 156 удаа, тус хөтөлбөрийн нийтийг хамарсан ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлуудад 15 удаа хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Мөн Баяннуур, Сагсай, Ногооннуур сумдад бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээний явцад сум хариуцсан мэргэжилтнүүд тогтмол хяналт тавьж бүлгийн ахлагчдаас тайланг фото зургийн хамт хүлээн авч хяналтыг хэрэгжүүлжээ.

Бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй ажилгүй иргэдийг тогтмол ажлын байраар хангасан 9 ажил олгогчтой гэрээ байгуулан ажилгүй 19 иргэнийг байнгын ажлын байртай болгосон байна. Мөн 2018 онд гэрээ байгуулсан 25 иргэний ажлын байранд

хяналтыг хийж холбогдох бичиг баримтыг үндэслэн 13 ажил олгогчид 83,2 сая төгрөгийн санхүүгийн урамшууллыг олгосон байна.

Жижиг зээл, эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 7 хувиараа хөдөлмөр хөдөлмөр эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж, гэрээ байгуулан 3,2 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлтийг олгосон байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамрагдсан Булган, Бугат, Буянт, Толбо, Улаанхус, Цэнгэл сум болон Цагааннуур тосгоны нийт 56 малчин өрхүүдэд сумдын ЗДТГ-аас байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран газар дээр нь очиж, хяналт тавьж ажилласан байна.

2020 онд Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсээс боловсруулж ХХҮГ-ын даргаар батлуулсан “Хөдөө сумдад ажиллах удирдамж”, “Ажиллах маршрут”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөд хяналт тавих ажлын төлөвлөгөө”-ний дагуу Алтанцөгц, Баяннуур, Дэлүүн, Толбо, Бугат, Сагсай, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумд болон Цагааннуур тосгон зэрэг 10 сумдад 2017-2020 онуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнтэй газар дээр нь очиж танилцан хяналт хийж, зөвлөгөө өгч, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, төлөхгүй байгаа иргэдтэй уулзаж төлбөр барагдуулах талаар сануулах, холбогдох хууль, журмыг танилцуулан, хяналтаар ажилласан талаар илтгэх хуудсаар танилцуулж, фото зургаар баримтжуулан тайлагнаж ажиллажээ.

Хяналт, шалгалтын явцад Бугат суманд ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 2019 онд хамрагдсан сүү, цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж авсан бүлэг нь тухайн тоног төхөөрөмжөө ажиллуулж чадахгүй байсныг ажлын хэсэг сум хариуцсан мэргэжилтэн болон бүлгийн гишүүдэд үүрэг чиглэл өгч ажилласны үр дүнд холбогдох хүмүүсээр тухайн тоног төхөөрөмжийг ажиллуулах аргачлалыг заалгаж бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ явуулсан байна.

Толбо сумаас 2019 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдсан бүлгийн 1 гишүүн тоног төхөөрөмжөө хуваан авч бүлгээс гарах хүсэлтэй байсныг зөвлөгөө мэдээлэл өгч ажилласны үр дүнд үйл ажиллагаагаа цааш үргэлжлүүлэхээр болсон байна.

Хяналтын явцад Сагсай сумын бүлгийн ажилд шаардлагатай 380 квт-ын цахилгааны асуудлыг сумын Засаг даргаар шийдвэрлүүлж ажиллажээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаанд газар дээр хяналтыг хэрэгжүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, эргэн төлөлтийг төлж барагдуулахыг шаардаж, хууль тогтоомжийг танилцуулж, үүрэг даалгавар өгч ажилласны үр дүнд 2020 онд нийт 260,3 сая төгрөг, үүнээс 11 дүгээр сард 29,8 сая төгрөг, 12 дугаар сард 50,0 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд гэрээнд заасан хугацаанд төслийн хэрэгжилтийн явцын тайлан, үйл ажиллагааны болон, санхүүгийн тайланг ХХҮГ-т тогтмол бүрэн ирүүлдэггүй байна.


ХХҮГ-аас төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчийн төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүлээн авч төслийн хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг дүгнэсэн, гарсан зөрчил дутагдлыг арилгуулсан, зөвлөмж зөвлөгөө өгсөн, үр дүнг тооцож дүн шинжилгээ хийсэн

талаар албажуулсан баримт материал аудитад ирүүлээгүй болно. Үүнээс үзэхэд ХХҮГ-ын Захиргаа хяналтын хэлтэс болон хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний зүгээс сангийн зарцуулалтад хийх хяналтын ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн талаар тайлагнадаггүй, үр дүнг үнэлж, дүн шинжилгээ хийсэн талаар баримт бичиг байхгүй байна.

Аудитын дүнгээр ХХҮГ-т хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгчидтэй байгуулсан гэрээнд заасны дагуу явцын тайланг хугацаанд нь хүлээн авч төслийн хэрэгжилтийн үйл явц, үр дүн, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналтыг хэрэгжүүлж, дүн шинжилгээ хийж, баримтжуулан ажиллах талаар зөвлөмж өгөв.

Аудитын дүнгээр ХЭДСангийн хөрөнгөөр худалдан авсан 15,8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийн зардлыг зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зургаан төсөл хөтөлбөрөөс эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгосон зээлийг хуваарийн дагуу гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хавсралтад заасан 441 иргэн, аж ахуйн нэгжийн хугацаа хэтэрсэн 729,3 сая төгрөгийн зээлийг санд эргэн төлүүлэх талаар нийтдээ 746,1 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ.

Холбогдох байгууллагын санал:



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдөж, батлагдсан төсөл, хөтөлбөр, салбарын бодлоготой уялдсан байна.
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас 2020 онд цар тахалтай холбоотой санхүүжилтийг дутуу олгосон байна.
3. Батлагдсан төсөл, хөтөлбөр салбарын байгууллагуудын саналд үндэслэгдсэн байна.
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байгаагаас 441 аж ахуйн, нэгж, иргэний 729.3 сая төгрөгийн зээлийн хугацааг хэтэрсэн байна.
5. Төсөл, хөтөлбөрийн жагсаалтад хэрэгжих хугацаа тодорхойгүй төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.
6. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулаагүй төлбөрөөс 14.9 сая төгрөгийн, зээл, тусламжийн орлогоос 24.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.
7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг батлдагдсан төсвийн дагуу зарцуулсан байна.
8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжсэн төслүүдийн гэрээг дүгнэж, үр дүнг тооцох, үнэлэх асуудал дутагдалтай байна.
9. Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.
10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээллийн бааз бүрдүүлж, нэгдсэн судалгаа, мэдээ гаргаж, дүн шинжилгээ хийсэн байна.
11. ХЭДС-гаас 2019, 2020 онд хэрэгжсэн хөтөлбөрийн явцад дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, үр дүнг тайлагнаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Б.Сьезхан-д:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгчидтэй байгуулсан гэрээнд заасны дагуу явцын тайланг хугацаанд нь хүлээн авч төслийн хэрэгжилтийн үйл явц, үр дүн, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналтыг хэрэгжүүлж, дүн шинжилгээ хийж, баримтжуулан ажиллах.

2. Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллуулахгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг төлүүлэх, хуулийн талаар сургалт сурталчилгаа хийх, хяналтыг хэрэгжүүлж, орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх.

ХАВСРАЛТУУД:**ХАВСРАЛТ 1:**

2019, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2019 он			2020 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	16,800.0	16,800.0	-	9,043.0	8,963.0	80.0
2	Ажилд зуучлах үйлчилгээ	11,690.0	11,690.0	-	12,402.1	11,198.3	1,203.9
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	39,230.0	35,661.0	3,569.0	-	-	-
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	526,600.0	523,240.0	3,360.0	514,506.5	379,965.3	134,541.2
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	180,340.0	177,715.0	2,625.0	3,380.0	-	3,380.0
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	305,500.0	278,807.2	26,692.8	-	-	-
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	97,340.0	83,811.7	13,528.3	100,967.5	87,477.5	13,490.0
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	41,280.0	41,280.0	-	35,200.0	30,000.0	5,200.0
9	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	108,500.0	108,500.0	-	-	-	-
10	Хүүгийн хөнгөлөлт	2,850.0	3,050.0	(200.0)	968.0	768.0	200.0
11	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	4,000.0	4,000.0	-	3,032.1	1,900.0	1,132.1
12	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт	2,800.0	2,800.0	-	2,250.0	2,250.0	-
13	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сан, бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах	15,965.0	15,965.0	-	22,690.0	17,167.0	5,523.1
14	Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3 талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавхи бэхжүүлэх сургалт	10,628.0	10,628.0	-	10,365.0	9,652.2	712.8
15	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	7,354.0	7,354.0	-	17,586.0	16,952.5	633.5
16	Хөтөлбөр төслийн хяналт, үнэлгээ	9,000.0	9,000.0	-	9,200.0	7,478.2	1,721.8
17	Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх, хэвлүүлэх	4,000.0	4,000.0	-	4,350.0	4,350.0	-
18	Хүүхэд хамгаалагч төсөл	4,704.0	4,704.0	-	4,704.0	3,604.0	1,100.0
19	Бичил бизнес эрхлэгчдэд мэдээлэл зээл, санхүүгийн бус үйлчилгээний талаар мэдээлэл түгээх	-	-	-	7,529.5	5,866.5	1,663.0
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарлагын дүн		1,388,581.0	1,339,005.9	49,575.1	758,173.7	587,592.4	170,581.3

ХАВСРАЛТ 2:

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн судалгаа

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	120	5,400.0	120	5400	-	-
	Үйлдвэрлэл дээрх сургалт	25	17,500.0	40	17500	(15.0)	-
	Мэргэжлийн болон давтан сургалт	71	16,330.0	136	12761,0	(65.0)	3,569.0
	Дүн	216	39,230.0	296	35,661.0	(80)	3,569.0

ХАВСРАЛТ 3:

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн судалгаа

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Санхүүгийн дэмжлэг	46	230,000.0	81	230,000.0	(35.0)	-
	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	140	4,200.0	56	840.0	84.0	3,360.0
	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	6	17,280.0	6	17,280.0		-
	Ажил олгогчид олгох дэмжлэг	21	83,220.0	25	83,220.0	(4.0)	-
	Нийтийг хамарсан ажил	400	111,900.0	393	111,900.0	7.0	-
	Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ	27	50,000.0	0	50,000.0	27.0	-
	Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	60	30,000.0	56	30,000.0	4.0	-
	Дүн	700	526,600.0	617	523,240.0	83	3,360.0
2020 он	Санхүүгийн дэмжлэг	58	291000,0	77	240000,0	-19	51000,0
	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	39	1,155.0	77	1,155.0	(38.0)	-
	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		24,952.0	121	4,424.0	(121.0)	20,528.0
	Ажил олгогчид олгох дэмжлэг	10	61,580.0	4	19,080.0	6.0	42,500.0
	Нийтийг хамарсан ажил	255	71,504.5	232	56,491.3	23.0	15,013.2
	Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ	18	34,315.0	21	28,815.0	(3.0)	5,500.0
	Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	60	30,000.0	34	30,000.0	26.0	-
	Дүн	440	514,506.5	566	379,965.3	(126)	134,541.2

ХАВСРАЛТ 4:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн 2019, 2020 онуудын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэсэн зардал	Зөрүү
----	----------	------------	--------------------	-------

		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах Санхүүгийн дэмжлэг	-	10,000,0	-	10,000,0	-	-
	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	15	150,000,0	15	150,000,0	-	-
	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	102	3,060,0	29	435,0	73.0	2,625.0
	Дүн	-	17,280,0	1	17,280,0	(1.0)	-
	Дүн	117	180,340.0	45	177,715.0	72	2,625.0
2020 он	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах	0	1200	0	0	0	1200
	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	2	2,180.0	0	-	2.0	2,180.0
	Дүн	440	3,380.0	566	-	2	3,380.0

ХАВСРАЛТ 5:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Малчин өрхийг малжуулах	56	280,000.0	56	256,000,0	-	24,000.0
	Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	3	3,000.0	-	307,0	3.0	2,692.8
	Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	180	22,500.0	10	22,500	170.0	-
	Дүн	239	305,500.0	66	278,807.2	173	26,692.8

ХАВСРАЛТ 6:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	24	1,680.0	24	1,680.0	-	-
	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	4	1,680.0	-	-	4.0	1,680.0
	Санхүүгийн дэмжлэг	12	60,000.0	23	60,000.0	(11.0)	-
	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	-	11,520.0	-	11,520.0	-	-
	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	82	2,460.0	22	330.0	60.0	2,130.0
	Хөдөлмөр эрхлэлтийн	16	4,640.0	-	-	16.0	4,640.0
	Дүн	138	74,300.0	47	73,530.0	91.0	6,450.0

	сургалт						
	Ажил олгогчийн урамшуулал	4	15,360.0	3	10,281.7	1.0	5,078.3
2019 он	Дүн	142	97,340.0	72	83,811.7	70	13,528.3
2020 он	Санхүүгийн дэмжлэг	17	86,640.0	32	75,000.0	(15.0)	11,640.0
	Борлуулалтын дэмжлэг болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	3	4,467.5	1	2,617.5	2.0	1,850.0
	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	16	480.0	32	480.0	(16.0)	-
	Ажил олгогчийн урамшуулал	2	9,380.0	2	9,380.0	-	-
2020 он	Дүн	440	100,967.5	566	87,477.5	(29)	13,490.0

ХАВСРАЛТ 7:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	17	14,280.0	19	14,280.0	(2.0)	-
	Санхүүгийн дэмжлэг	9	27,000.0	20	27,000.0	(11.0)	-
	Дүн	26	41,280.0	39	41,280.0	(13)	-
2020 он	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	-	-	-	-	-	-
	Санхүүгийн дэмжлэг	12	35,200.0	15	30,000.0	-	5,200.0
	Дүн	12	35,200.0	15	30,000.0	-	5,200.0

ХАВСРАЛТ 8:

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн		Гүйцэтгэсэн зардал		Зөрүү	
		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Итгэлийн зээл		100,000.0	6	100,000.0	-	-
	Сургалт, сурталчилгаа хяналт үнэлгээний зардал		8,500.0		8,500.0		-
	Дүн	-	108,500.0	6	108,500.0	-	-

ХАВСРАЛТ 9:

2019, 2020 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа

Он	Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэсэн зардал	Зөрүү
----	----------	------------	--------------------	-------

		Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг	Хүний тоо	Мянган төгрөг
2019 он	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	2,090	16,800.0	2117	16,800.0	(27.0)	-
	Ажилд зуучлах үйлчилгээ	1,000	11,690.0	1160	11,690.0	(160.0)	-
	Хүүгийн хөнгөлөлт	11	2,850.0	-	2850.0	11.0	-
	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	-	4,000.0	-	4,000.0	-	-
	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт	-	2,800.0	-	2,800.0	-	-
	Хөдөлмөр эрхлэлтийн бүртэл, мэдээллийн сан, бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах	-	15,965.0	-	15,965.0	-	-
	Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3 талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавхи бэхжүүлэх сургалт	-	10,628.0	-	10,628.0	-	-
	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	-	7,354.0	-	7,354.0	-	-
	Хөтөлбөр төслийн хяналт, үнэлгээ	-	9,000.0	-	9,000.0	-	-
	Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх, хэвлүүлэх	-	4,000.0	-	4,000.0	-	-
	Хүүхэд хамгаалагч төсөл	-	4,704.0	-	4,704.0	-	-
	Дүн	3,101	89,791.0	3,277	89,791.0	(176)	
	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	952	9,043.0	823	8,963.0	129	80
	Ажилд зуучлах үйлчилгээ	1,772	12,402.1	507	11,198.3	1,265.0	1,203.9
2020 он	Хүүгийн хөнгөлөлт	-	968.0	-	768.0	-	200.0
	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	-	3,032.1	-	1,900.0	-	1,132.1
	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт	-	2,250.0	-	2,250.0	-	-
	Хөдөлмөр эрхлэлтийн бүртэл, мэдээллийн сан, бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах	-	22,690.0	-	17,167.0	-	5,523.1
	Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3 талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавхи бэхжүүлэх сургалт	-	10,365.0	-	9,652.2	-	712.8
	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	-	17,586.0	-	16,952.5	-	633.5
	Хөтөлбөр төслийн хяналт, үнэлгээ	-	9,200.0	-	7,478.2	-	1,721.8
	Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх, хэвлүүлэх	-	4,350.0	-	4,350.0	-	-
	Хүүхэд хамгаалагч төсөл	2	4,704.0	-	3,604.0	2.0	1,100.0
	Дүн	2,726	96,590.2	1,330	84,283.1	1,396	12,307.1



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/14

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүн" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга /Б.Сьезхан/-д зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмж, албан шаардлагыг статистик мэдээний бүртгэлд авч, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Х.Манаргүл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



D:\bichig hereg\2020\tushaal.doc

Баян-Өлгий аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, тэргүүлэх
аудиторын /Д.О.Оны
08 дугаар сарын 22-ны өдрийн
11/4 тоот тушаалын хавсралт

8317144071
БЮА0074 9 /сая.төг/

№	Байгууллагын нэр	Төлбөрийн		Албан шаардлагын	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар			442	729.3
2	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар			4	15,8
3	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар			2	1.0
	ДҮН			448	746,1